



11

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 06

Номгон

Г

Г

Албан тушаалын сул орон тоонд  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4, 5 дугаар зүйлийн 5.7, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэ оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан Төрийн захиргааны гүйцэтгэх, туслах болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сул ажлын байрыг нөхөх тусгай шалгалтын тайланг хянан үзээд сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авсан Ц.Энхжаргалыг Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дотоод аудитораар, Д.Мөнххандыг Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дотоод аудитораар, Б.Эрдэнэчuluуныг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Бууцагаан сумын газрын даамлаар, Б.Нармандахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Баянхонгор сумын газрын даамлаар, Х.Баасанжаргалыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Баянхонгор сумын газрын даамлаар, Т.Номинчимэгийг Их богдын цогцолборт газрын Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтнээр, Д.Монголжийбууг Соёл урлагийн газрын төлөвлөлт, тайлагналт, мэдээлэл технологи, цахимжилтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр, Г.Гомбосурэнг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Баянбулаг сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, Б.Лхамцэдэнг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Баянхонгор сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, Ж.Ёндөнпилийг Мал эмнэлгийн газрын Баян-Овоо сум дахь Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагчаар, Ж.Жамъяндагвыйг Мал эмнэлгийн газрын Баян-Овоо сум дахь Мал эмнэлгийн тасгийн Тархварзүйчээр, Г.Хэрлэнчимэгийг Соёл урлагийн газрын Урлаг уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, А.Өлзийсайханыг Боловсрол, шинжлэх ухааны газрын Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургалт, сурах бичиг, сургалтын орчин хариуцсан мэргэжилтнээр, Д.Болормааг

Соёл, урлагийн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн даргаар, Б.Цогзолмааг Баянхонгор сумын 6 дугаар багийн зохион байгуулагчаар, Д.Наранмандахыг Баянхонгор сумын 3 дугаар багийн зохион байгуулагчаар, Т.Мөнхтуяаг Баянхонгор сумын 9 дүгээр багийн зохион байгуулагчаар, Г.Долгорсүрэнг Баянхонгор сумын 1 дүгээр багийн зохион байгуулагчаар, Ч.Өлзийбадрахыг Баянхонгор сумын 7 дугаар багийн зохион байгуулагчаар, Б.Алтанчимэгийг Зооноз өвчин судлалын төвийн даргаар тус тус томилуулахаар нэрийг дэвшүүлсүгэй.

2. Төрийн албаны тусгай шалгалтад хамгийн өндөр оноо авч сул ажлын байранд нэр дэвшигдсэн иргэдийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 22.1.3, 22.1.5-д тавигдсан шаардлагыг хангаж байгаа баримтыг холбогдох байгууллагаас авч хянахыг холбогдох байгууллагын дарга нарт сануулсугай.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийг чанд сахиж, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, алдаа зөрчилгүй ажиллахыг тухайн албан тушаалд нэр дэвшигчдэд зөвлөсүгэй.



ДАРГА

Д.ЭНХЖАРГАЛ